



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2018.02
2018.02



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.


Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

2017 онд аймгийн хүн ам 87243 болж өмнөх оноос 2,2 хувиар буюу 1912 хүнээр нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд Хүрээмарал сумаас бусад сумын хүн ам өссөн байна. Нийт хүн амыг хүйсээр нь авч үзвэл 50.6 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Байршилаар авч үзвэл 33.8 хувь нь аймгийн төв, 11.9 хувь нь сумын төв, 52.6 хувь нь хөдөө, 1.6 хувь тосгонд байна.

2017 онд Баянхонгор аймаг 26270 өрхтэй болж өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсчээ. Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл 34.4 хувь нь аймгийн төвд, 12.1 хувь нь сумын төвд, 52.0 хувь нь хөдөөд, 1.5 хувь нь тосгонд байна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2018 оны 02 дугаар сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 1738.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 609,3 сая төгрөгөөр буюу 53.9 хувиар өссөн байна. 2018 оны 02 дугаар сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг БаянОвоо, Өлзийт, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ЦХТА орлого /суутган-1/ 170.5 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 2.8 сая төгрөг, ИОТТХ 14.9 сая төгрөг, агаарын бохирдол /авто/ татвар 0.2 сая төгрөг, хог хаягдлын хураамж 0.07 сая төгрөгөөр тус тус тасарч, Улсын тэмдэгтийн хураамж 11.9 сая төгрөг, бууны татвар 1.7 сая төгрөг, ус ашигласны төлбөр 1.7 сая төгрөг, хог хаягдлын хураамж 4.1 сая төгрөг, НӨАТатвар 57.7 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 16.7 сая төгрөг, Түгээмэл тархацтай АМАТ 0.3 сая төгрөг, өөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 3.2 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.4 хувь, ЦХТА орлого 35.5 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 0.7 хувь, хүү торгууль 7.6 хувь бусад төлбөр хураамж 29.9 хувийг тус тус эзэлж байна



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2018 оны 03 дугаар сарын 05-ны байдлаар арилжааны банкуудаар 149725.6 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 2 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 148041.5 сая төгрөг байгаагийн 144414.6 сая төгрөг нь хэвийн зээл, 2763.8 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2547,3 сая нь чанаргүй зээл байна.

2018 оны эхний 2 сарын байдлаар иргэдийн хадгаламж 76464.9 сая төгрөг болжээ. Үүний 16136.7 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 60122.9 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 65122.8 сая төгрөг болжээ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 02 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 1.8 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд голлож мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 3.0 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, согтууруулах ундаа, тамхиний бүлгийн барааний үнэ, тээврийн бүлгийн барааны үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 02 дугаар сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 9.3 хувиар өссөн байгаа нь голлож тээврийн бүлгийн барааны үнэ, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ, боловсролын үйлчилгээний бүлгийн барааны үнэ, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

Баянхонгор аймгийн хэрэглээний үнийн индекс	2018.0	2018.02	2018.02	2018.02
	2 /	/	/	/
	2015	2017.02	2017.12	2018.01
ЕРӨНХИЙ ИНДЕКС	114.5	109.3	103.0	101.8
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	112.2	107.4	106.5	103.6
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	107.6	106.5	105.2	101.7
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	115.0	108.4	101.7	100.8
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	105.0	104.5	100.4	100.2
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	113.6	107.8	101.8	100.4
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	125.5	106.1	100.6	100.6
07. ТЭЭВЭР	116.9	114.7	104.0	104.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.2	99.2	100.0	100.0
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	113.7	97.0	99.5	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	139.2	136.0	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	127.3	115.5	100.0	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	118.6	110.5	99.5	100.2



АЖ ҮЙЛДВЭР

2018 оны 02 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 940.1 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 328.8 сая төгрөгөөр буюу 33.8 хувиар буурсан байна

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

Нийт борлуулалт	Хоёрдугаар сар		
	2017	2018	2018.02/2017.02
	645167.0	974055.7	66.2

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Хоёрдугаар сар		
		2017	2018	2018.02/2017.02
Нүүрс	Мян.тн	3.6	8.0	11.6
Нарийн боов	тн	8.3	5.3	13.6
Талх	тн	10.5	5.2	15.7
Хиам	тн	0.8	0.0	1.6
Дулаан	Мян.Гкал	36.4	90.1	126.5
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	22.2	67.1	89.3



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Баянхонгор аймгийн мал 2017 онд 4587738 болж өмнөх оноос 8.3 хувиар буюу 351417 толгойгоор өсчээ.

Аймгийн дүнгээр мал таван төрөл дээрээ өссөн байна. Нийт малыг сүргийн бүтцээр нь авч үзвэл адуу 3.9 хувь, үхэр 5.2 хувь, тэмээ 1.2 хувь, 30.1 хувь хонь, ямаа 59.5 хувийг тус тус эзэлж байна. Баяновоо, Богд сумаас бусад 18 сум малаа 1.4-18.0 хувиар өсгөсөн байна.

Улсын хэмжээнд манай аймаг нийт малын тоогоороо 5 дугаарт орж, ямаан сүргийн тоогоороо 1 дүгээрт, тэмээн сүргийн тоогоороо 2 дугаарт орж байна.

Баянхонгор аймгийн 02 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр 129182 толгой үүнээс өвчнөөр 31, хээлтэгч 18917 толгой мал тус тус хорогдсон нь оны эхний нийт малын 2.8 хувийг эзлэж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 14, адуу 1859, үхэр 3524, хонь 26935, ямаа 96850 толгой тус тус хорогджээ. Мөн нийт хорогдсон малын 14.6 хувь буюу 18917 толгой хээлтэгч мал хорогдсон байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны 02 дүгээр сард 3992 хүнд 942.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 825 эхчүүдэд 56.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 6447 эхэд 870.9 сая төгрөг, алдар цолтой 22 ахмадуудад 7.1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 164 хүнд 70.4 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 85 хүнд 16.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



ЭРҮҮЛ МЭНД

2018 оны 02 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 322 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 58 төрөлтөөр өссөн байна. Нийт төрсөн эхийн 86.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 13.7 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 02 сарын байдлаар 6 гарчээ.

02 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 44 тохиолдол буюу 68.2 хувь, тэмбүү 40 тохиолдол буюу 70 хувь, хүйтэн 30 тохиолдол буюу 66,6 хувиар тус тус өсч, арьсны мөөгөнцөр 10 тохиолдол буюу 0.0 хувь, сүрьеэ 7 тохиолдол буюу 0.0 хувь, трихомониаз 45 тохиолдол буюу 27.0 хувиар буурсан, халдварт гепатит 2 тохиолдол буюу 0.1 хувиар буурсан, гахай хавдар 1 тохиолдол 0.0 хувь буюу өөрчлөлтгүй байна.

Аймгийн хэмжээнд эхний 02 дугаар сарын байдлаар нас баралтын 102 тохиолдол бүртгэгдсэний 9.2 хувь нь эмнэлэгт нас барснаас 0.09 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны 02 сард 3057 байсан бол энэ оны эхний 02 сарын байдлаар 3346 болж 289 дуудлага буюу 8.7 хувиар өссөн байна.



ГЭМТ ХЭРЭГ

2018 оны эхний 02 сард аймгийн хэмжээнд нийт 93 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 16.2 хувиар өссөн байна. Хэргийн илрүүлэлт 12.2 хувьтай байна. Хэргийн гаралт 5 суманд буурч, 7 суманд өсч, 2 суманд ижил түвшинд, 6 сумд гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. Гэмт хэрэгт 29 хүн холбогдон шалгагдсан ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63 нэгжээр буюу 68.4 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 96 иргэн хохирч 5 хүн нас барж, 38 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 118.7 сая төгрөгийн хохирол учирснаас 11.9 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 10 хувьтай байна. Амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 100 хувь, иргэдийн өмчийн хулгай 19 хувь, тээврийн хэрэгслийн хулгай 2 нэгжээр буюу 50 хувиар, дээрэм 4 нэгжээр буюу 100 хувь, танхай 4 нэгжээр буюу 100 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 3 нэгжээр буюу 60 хувиар тус тус буурсан байна. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 4 нэгжээр буюу 100 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12 нэгжээр буюу 42.8 хувь, малын хулгай 4 нэгжээр буюу 66.6 хувь, залилан 2 нэгжээр буюу 66.6 хувиар тус тус өссөн байна.

Энэ хугацаанд 2494 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1048 буюу 72.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**